



МОНГОЛ УЛСЫН  
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

# ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЗОРИУЛСАН  
ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН





МОНГОЛ УЛСЫН  
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

# ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НҮҮЦҮҮН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН

Эмхэтгэсэн: Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтэс

Хэвлэлийн хуудас: 2.25 xx

Цаасны хэмжээ: 145x210

Хэвлэсэн тоо: 300 ширхэг

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: О.Эрдэнэцогт

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

# АГУУЛГА

---

1.	Төрийн болон албаны нууцын тухай ойлголт, эрх зүйн орчин .....	6
2.	Аюулгүй байдлын гэрчилгээ авах тухай ойлголт .....	8
3.	Байгууллагын удирдах албан тушаалтны эрх, үүрэг .....	10
4.	Төрийн болон албаны нууцтай танилцах .....	11
5.	Төрийн нууцтай танилцах эрх олгох .....	14
6.	Төрийн болон албаны нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох .....	20
7.	Нууц баримт бичиг, бусад тээгчийг хүлээнцэх .....	22
8.	Нууц мэдээлэл боловсруулах, хадгалах, дамжуулах систем, сүлжээ, техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах .....	23
9.	Нууцын биет хамгаалалт .....	25
10.	Тагнуулын байгууллагын эрх, үүрэг .....	28
11.	Хууль зөрчигчид хүлээнлгэх хариуцлага .....	30



# 1

## ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Төрийн болон албаны нууцын тухай хууль Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлагдаж, 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөк эхэлсэн.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоолоор дараах журмуудыг баталсан:

- “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”
- “Төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт шалгалт хийх журам”
- “Төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах журам”
- “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”
- “Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах журам”.

Мөн “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг батлав.

### ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ





## ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ, НУУЦЛАХ ХУГАЦАА

“Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээлэл

“Онц чухал нууц”

**30 жил**

“Маш нууц”

**20 жил**

“Албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээлэл

“Нууц”

**10 жил**



# 2

## АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГЭРЧИЛГЭЭ АВАХ ТУХАЙ ОЙЛГОЛТ



Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдсанаар хуулийн этгээд нууцад хамаарах ажил, үйлчилгээ гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдсэн.

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон албаны нууцыг ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх хуулийн этгээдийг тагнуулын байгууллага судалж, шалган нууцад хамаарах ажил, үйлчилгээ явуулах боломжтой гэж үзсэн бол аюулгүй байдлын гэрчилгээ олно.

“Аюулгүй байдлын гэрчилгээ” гэж төрийн байгууллагын нууцад хамаарах тодорхой үйл ажиллагаа явуулахаар сонгогдсон хуулийн этгээд нь тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан нууц хамгаалах тухай хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлага хангаж байгаа эсэхийг тагнуулын байгууллагаас хянан магадлаж, бичгээр эрх олгохыг хэлнэ.

### НУУЦАД ХАМААРАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ БЮОУ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГЭРЧИЛГЭЭ АВАХ

Төрийн байгууллагын сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээд нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6.3 дахь хэсэгт заасны дагуу Нууц үйл ажиллагаа явуулах эрх бүхий аюулгүй байдлын гэрчилгээ авах хүсэлтийг бичгээр гаргана.

- Аюулгүй байдлын анкет (Маягт 6)
- Маягт 6-д дурдсан мэдээллийг нотлох баримт бичгийг нотариатаар баталгаажуулах (Улсын бүртгэлийн гэрчилгээ, хуулийн этгээдийн дүрэм, дотоод журам, ажил гүйцэтгэхэд холбоотой нууц баримт бичиг шилжүүлж авах үйл ажиллагааны төлөвлөгөө, хуулийн этгээлийн товч танилцуулга, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын лавлагаа, харилцаа банкны тодорхойлолт г/м)

Хуулийн этгээдийн хүсэлтийг Тагнуулын ерөнхий газрын тусгайлсан үүрэг бүхий ажлын хэсэг хянан үзэж, баримт бичгийн болон хууль зүйн үндэслэлтэй байх тохиолдолд хянан магадлах ажиллагааг тухайн хуулийн этгээдийн байранд хийнэ.

Хянан магадлах ажиллагаа – Хуулийн этгээд нь Төрийн болон албаны нууцын тухай хууль, нийтлэг журамд заасан нууцын хадгалалт, биет хамгаалалт, нууцад хамаарах ажил гүйцэтгэхэд шаардлага хангаж байгаа эсэх талаар дүгнэлт хийх.



#### АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНКЕТ

(Маятг 6)

20.....оны ... дугаар  
сарын .....ны өдөр

Улаанбаатар  
хот

№	Шаардлагатай мэдээлэл	Хуулийн этгээдийн мэдээлэл
1	Хуулийн этгээдийн нэр	
2	Удирдлагын нэр	
3	Улсын бүртгэлийн дугаар	
4	Үйл ажиллагааны чиглэл	
5	Банкин дахь дансны дугаар	
6	Нууцад хамаарах уйл ажиллагаа явуулхаар хүснэгт гаргасан чиглэл	
7	Өмнө нь Нууцад хамаарах уйл ажиллагаа явуулж байсан эсэх	
8	Үүсгэн байгуулгачин нэр, регистрийн дугаар	
9	Хөрөнгө оруулалтын хэлбэр (гадаад, дотоод, холимог)	
10	Гадаад улс дахь салбар, нэгж	
11	Ажилтны тоо	
12	Ажил гүйцэтгэхэд ашиглах техник хэрэгслийн тоо хэмжээ	
13	Дотоод, гадаад цахим сүлжээнд холбогдоон байдал	
14	Зээлийн хэмжээ, төлөлт	
15	Бусад этгээдийн ёмни хүлээсэн үүрэг	

ХҮСЭЛТ ГАРГАСАН:

/...../

/гарын үсгийн тайлап/

/тамга дарж баталгаажуулна/

**Хуулийн этгээд нь нууцад хамаарах ажил гүйцэтгэхдээ нууц баримт бичиг шилжүүлэн авах, хүлээлгэж өгөхдөө “Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д заасан зохицуулалтыг мөрдлөг болгох**

- Аюулгүй байдлын гэрчилгээ олгогдоогүй тохиолдолд нууц баримт бичиг шилжүүлэн авах, боловсруулахыг хориглоно.
- Аюулгүй байдлын гэрчилгээ нь тухайлсан буюу нэг удаагийн ажил гүйцэтгэхэд олгох бөгөөд хуулийн этгээд нууцад хамаарах өөр ажил гүйцэтгэх тохиолдолд дахин тагнуулын байгууллагад хандах ба Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6.8 дахь хэсэгт заасны дагуу аюулгүй байдлын гэрчилгээнд заагаагүй уйл ажиллагаа явуулхаыг хориглоно.
- Аюулгүй байдлын гэрчилгээг бусад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.

ХОРИГЛОНО





# 3

## БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ



### ЭРХ

- ▶ Эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах
- ▶ Эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд байгаа төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавих
- ▶ Төрийн болон албаны нууцыг хамгаалах арга, хэрэгслийг боловсронгуй болгох, шаардлагатай хөрөнгийг төсөвтөө тусгаж, шийдвэрлүүлэх
- ▶ Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлах, бэлэн байдлыг хангах

### ҮҮРЭГ

- ▶ Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд төрийн болон албаны нууцыг хамгаалах ажлыг зохион байгуулах
- ▶ Дотооддоо дагаж мөрдөх төрийн болон албаны нууцыг хамгаалах журам тогтоох
- ▶ Харьяа салбар, байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавих
- ▶ Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг заавал биелүүлж, хариу мэдэгдэх
- ▶ Нууц хамгаалах ажилтны чиг үүрэг, хариуцлагыг ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж, батлах
- ▶ Нууц мэдээлэл боловсруулах, хадгалах, дамжуулах мэдээллийн систем, сүлжээ, техник хэрэгслийг аливаа аюул занал, хууль бус үйлдээс хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг авах



# 4

## ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦТАЙ ТАНИЛЦАХ



Албан тушаалтан эрхлэх ажил үүргийн дагуу төрийн нууцтай танилцах бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан тодорхой нөхцөл, шаардлагыг хангаж буй Монгол Улсын иргэн төрийн нууцтай танилцах боломжтой.

Өөрөөр хэлбэл албан тушаалтан, иргэн төрийн нууцтай танилцахын тулд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан аюулгүй байдлын шалгалтад хамрагдахыг өөрөө бичгээр зөвшөөрсөн, тагнуулын байгууллагаас хийх аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн, нууц задруулахгүй байх батлагааг бичгээр гаргасан байна.

Тагнуулын байгууллагаас зохих хариу өгөөгүй байхад албан тушаалтан, иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгохыг хориглоно.

### ТАНИЛЦАХ НӨХЦӨЛ:

01

Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлага тухайн байгууллагын хариуцсан төрийн нууцтай танилцах албан тушаалтын жагсаалтыг тагнуулын байгууллагын саналыг авч батална.

02

Төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг өөрөө бичгээр зөвшөөрсөн

03

Тагнуулын байгууллагаас явуулах аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн

04

Төрийн нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасан



### Аюулгүй байдлын шалгалтын дүн

Төрийн нууцтай танилцах  
эрх бүхий албан  
тушаалтан

Хяналт, шалгалтын болон  
тодорхой ажил, үүргийг  
хэрэгжүүлэх

### Байгууллагын удирдлагын шийдвэр

Албаны нууцтай  
танилцах

### ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ТУСГАЙ НӨХЦӨЛ:



Хуулиар хориглоогүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд төрийн болон албаны нууцтай зэрэглэл харгалзахгүй танилцана.



Хуулиар хориглоогүй бол Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлын хүрээнд төрийн болон албаны нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.



Төрийн болон албаны нууцад хамаарах асуудлыг хянан шалгах зорилгоор Улсын Их Хурлаас байгуулсан ажлын хэсгийн гишүүн, эсхүл энэ зорилгоор тусгайлан эрх олгогдсон хүн тухайн шалгах асуудлын хүрээнд хуулиар танилцуулахыг хориглосноос бусад төрийн болон албаны нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.



Гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж болон гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд холбогдох мэдээлэлтэй зөвхөн шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны дарга, гишүүд танилцах бөгөөд бусад хүн танилцахыг хориглоно.



Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, мөрдөн байцаач зөвхөн шалгаж шийдвэрлэх тодорхой хэрэг, маргаанд хамаарах төрийн болон албаны нууцтай хуулиар тогтоосон журмын дагуу танилцана.



Дээрх албан тушаалтнууд болон Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын дарга, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга аюулгүй байдлын шалгалтад хамрагдахгүй бөгөөд төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа гаргана.



## ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ БАРИМТ, БИЧИГТЭЙ ТАНИЛЦАХ:

/Маягт 9/ Бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурж танилцана.



Нууц баримт бичигтэй зөвхөн ажлын байранд танилцаж ашиглана.



Ажлын цаг дууссаны дараа нууц баримт бичгийг сейфэнд хадгална.



Шаардлагатай тохиолдолд нууц хамгаалах ажилтанд хадгалуулж болно.

- Нууцын албан хэрэг хөтглөлт
- Ирсэн нууц баримт бичиг хүлээж авах
- Нууц баримт бичиг, нууц тээгч илгээх
- Нууц баримт бичиг олшруулах

Нууц хамгаалах  
ажилтан хариуцна

Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан та зөвхөн өөрийн албан үүрэгт хамаарах, танилцвал зохих түвшний эрхийн хүрээнд хамаарах нууц баримт бичигтэй танилцана.





# 5

## ТӨРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ ОЛГОХ



### ШААРДЛАГА

Төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг өөрөө бичгээр зөвшөөрсэн

Төрийн нууцыг задруулахгүй байх баталгаа бичгээр гаргасан

Тагнуулын байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн

Эрхлэх албан тушаал тань  
Төрийн нууцтай танилцах  
эрх бүхий албан тушаалтны  
жагсаалтад багтсан эсэхийг  
нягтлах

Байгууллагын нууц хамгаалах  
ажилтан таниас аюулгүй  
байдлын шалгалтад хамрагдах  
зөвшөөрлийг бичгээр  
гаргуулан авна

Та төрийн нууц задруулахгүй  
байх баталгааг бичгээр  
гаргана

Тагнуулын байгууллагаас  
холбогдох хууль тогтоомжид  
заасны дагуу Аюулгүй  
байдлын шалгалтыг  
хэрэгжүүлнэ



**АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНД ДАРААХ ҮНДЭСЛЭЛЭЭР ТӨРИЙН НУУЦТАЙ  
ТАНИЛЦАХ ЭРХ ОЛГОХООС ТАТГАЛЗНАА:**

-  Төрийн нууцтай танилцах шаардлага, нөхцөлийг хангаагүй
-  Аюулгүй байдлын шалгалтад хамрагдах, төрийн болон албаны нууцыг хамгаалах баталгааг бичгээр гаргаж өгөхөөс татгалзсан;
-  Аюулгүй байдлын шалгалтад өөрийн тухай болон холбогдох бусад мэдээллийг танилцуулаагүй, эсхүл худал мэдээлсэн;
-  Төрийн болон албаны нууцыг хамгаалах журмыг удаа дараа, эсхүл ноцтой зөрчиж байсан
-  Гэмт хэрэг санаатай үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн, эсхүл эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа
-  Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтээ гаргасан
-  Сэтгэцийн өвчин, эмгэгтэй нь тогтоогдсон
-  Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаанаас хамаарлтай



### ТӨРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ ОЛГОХ:

Байгууллагын Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж материал бэлдэнэ.



- Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад орсон албан тушаалтан
- Хяналт шалгалт хийх, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, суралцах явцад тодорхой түвшинд төрийн нууцтай зайлшгүй танилцах шаардлагатай албан хаагч, иргэн



Нууц хамгаалах ажилтан материалыг хянаж аюулгүй байдлын шалгалт хийлгэхээр Тагнуулын ерөнхий газарт хүргүүлнэ.



Тагнуулын байгууллага аюулгүй байдлын шалгалтыг тогтоосон хугацаанд, зохих журмын дагуу явуулна /20 хүртэл хоног/.



Тагнуулын байгууллагаас тухайн иргэн албан хаагчид тодорхой түвшинд төрийн нууцтай танилцах эрх олгох эсэх талаар хүсэлт гаргасан байгууллагад бичгээр мэдэгднэ.



**Тагнуулын байгууллагаас зохих хариу өгөөгүй байхад тухайн иргэн, албан хаагчийг төрийн нууцтай танилцах албан тушаалд томилох, эсхүл төрийн нууцтай танилцах эрх олгохыг хориглоно.**



Байгууллагын нууц хамгаалах ажилтан тухайн иргэнд төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийг судлуулж, нууцтай танилцахад түүний тодорхой эрх хязгаарлагдах, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд зохих хариуцлага хүлээх, тэдгээртэй холбоотой бусад үр дагавар үүсэх тухай тайлбарлаж нууц задруулахгүй байх баталгааг гаргуулан авна.

Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журамд заасан шаардлагыг хангасан иргэнийг төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалд томилох, эсхүл төрийн нууцтай танилцах эрх олгох тухай байгууллагын даргын шийдвэр гаргана.

#### АЛБАНЫ НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ ОЛГОХ:

Албаны нууцтай танилцах албан тушаалд томилох

Нууц задруулахгүй байх баталгаа авах

Хяналт шалгалт хийх, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, суралцах явцад тодорхой түвшинд төрийн нууцтай зайлшгүй танилцах шаардлагатай албан хаагч, иргэнд

Байгууллагын дарга зөвшөөрөл олгоно. /Маягт 1/

Нууц задруулахгүй байх баталгаа авах

#### АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГАЛТАД ХАМРАГДАХ АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭН ЯМАР МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтын жагсаалтад дурдсан албан тушаалд томилох хүнийг аюулгүй байдлын шалгалтад хамруулахдаа тухайн байгууллага дараах баримтыг бүрдүүлж, тагнуулын байгууллагад хүргүүлнэ:

- Албан тушаалтныг аюулгүй байдлын шалгалтад хамруулах тухай албан бичиг
- Нэр дэвшигч аюулгүй байдлын шалгалтад хамрагдахыг өөрөө зөвшөөрсөн зөвшөөрөл хуудас



## МОУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГАЛАД ХАМРАГДАХ ЗӨВШЕӨРӨЛ

20 ... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Монгол Улсын иргэн ..... регистрийн дугаартай,  
-ны ..... би Терийн  
 болон албаны нууцын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасны дагуу  
 албан тушаал, ажил үүргийн дагуу териийн нууцтэй танилцахаар нэр дэвсэнтэй  
 холбогдуулан аюулгүй байдлын шалгалаад хамрагдахыг зөвхөөр байна.

ЗӨВШҮҮРӨЛ ГАРГАСАН: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

ЗӨВШӨӨРӨЛ ГАРГУУЛСАН: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

- “Нүүц хамгаалах болон төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчийн анкет”-ыг үнэн, зөв бөглөх шаардлагатай. /Энэхүү анкетийг худал мэдүүлсэн тохиолдолд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасны дагуу төрийн нууцтай танилцах эрх олгооос татгалзах үндэслэл болохыг анхаарна уу/

1.15. Бонусы				
Соответствия	Этапы процесса	Типовые акции	Зависимые бонусы	Дополнительные действия

1.17. Хаділдер жарығы			
Анықтамалық жарығы	Андан тұшан	Андан төрле тәсіл	Андан тегесе тәсіл



- Байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь таны холбогдох баримт бичиг (иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, боловсролын гэрчилгээ, диплом... гэх зэрэг)-ийг бүрдүүлэн биечлэн тутгаж шалгасны дараа холбогдох материалыг нууц хамгаалах ажилтанд шилжүүлэн өгнө. Нууц хамгаалах ажилтан материалыг хянаж, албан бичгийн хамт дутгуйнд хийж битүүмжлэн аюулгүй байдлын шалгалт хийлгэхээр тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

### НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХИЙН ТҮВШИН:

Тагнуулын байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн албан тушаалтан, иргэнд танилцах мэдээллээс нь хамаарч нууцтай танилцах эрх олгоно.

Танилцах эрхийн түвшин 3 төрөлтэй байх бөгөөд төрийн болон албаны нууцын дараах зэрэглэлийн мэдээллэлтэй танилцах эрхтэй байна:

- Нэгдүгээр түвшин-“онц чухал нууц”, “маш нууц”, “нууц” зэрэглэлийн мэдээлэл;
- Хоёрдугаар түвшин-“маш нууц”, “нууц” зэрэглэлийн мэдээлэл;
- Гуравдугаар түвшин-“нууц” зэрэглэлийн мэдээллэлтэй танилцах эрхтэй.

**Албан тушаалтан, иргэнийг түүнд олгосон нууцтай танилцах эрхийн түвшинд хамаарахгүй мэдээллэлтэй танилцуулахыг хориглоно.**





# 6

## ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ



### ТАНИЛЦАХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ:

Шүүхийн шийдвэр гарч хүчин төгөлдөр болох, эсхүл албаны шалгалтын дүн гарах хүртэл

Гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан

Нууц хамгаалах журам зөрчсөн үйлдэлд шалгагдаж байгаа

### ХҮЧИНГҮЙ БОЛГОХ:

Тагнуулын ерөнхий газар дараах тохиолдолд хүчингүй болгоно:

Ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн

Ажил гүйцэтгэх гэрээ дуусгавар болсон

Журам, үүргээ удаа дараа болон ноцтой зөрчсөн

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан нөхцөл илэрсэн

### НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНИЙ ҮҮРЭГ

- ▶ Төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийг сахин биелүүлэх
- ▶ Танилцсан болон ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн төрийн болон албаны нууцыг хамгаалах, ажиллах хугацаанд, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа ил болгох хүртэл хугацаанд задруулахгүй байх
- ▶ Төрийн болон албаны нууцыг задруулах, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- ▶ Нууц задрах, үрэгдэх нөхцөл байдал бий болсон, эсхүл үрэгдсэн, задарсан, нууц хамгаалах журам зөрчигдсөн бол нууц хамгаалах ажилтанд нэн даруй мэдэгдэх
- ▶ Албаны болон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон, өөр ажил, албан тушаалд шилжих тохиолдолд өөрт нь итгэмжлэн хариуцуулсан төрийн болон албаны нууц тээгчийг зохих ёсоор хүлээнгэн өгөх, албан үүргийн хувьд танилцсан төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргах
- ▶ Хуульд өөрөөр заагаагүй бол хувийн хөргээр гадаад улсад зорчих тохиолдолд байгууллагадаа урьдчилан бичгээр мэдээлэх



## НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ



Нууц баримт бичиг, бусад тээгчийг байгууллагын удирдлагын зөвшөөрөлгүйгээр байгууллагаас гадагш гаргах



Нууц баримт бичиг, бусад тээгчийг байгууллагын удирдлагын зөвшөөрөлгүй, эсхүл бүртгэхгүйгээр бусдад дамжуулах, танилцуулах



Нууц баримт бичигтэй танилцах эрхгүй хүний дэргэд нууц мэдээлэл, түүнийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ярих, хэлэх



Нууц баримт бичгийг албаны бус, холбогдох байгууллагаас баталгаажуулаагүй компьютер, техникикхэрэгсэлашиглан боловсруулах



Албан үүрэгтээ үл хамаарах нууц мэдээлэлтэй танилцах, хадгалах, тэмдэглэж авах, опшруулах



Нууц баримт бичиг, бусад тээгчийг зориулалтын бус байранд хадгалах



Нууц баримт бичиг, бусад тээгчийг хадгалж байгаа байр, өрөө тасалгаа, сейф, шүүгээг цоожлохгүй орхих, онгорхой байлгах



Нууц баримт бичгийг ажлын байранд ил задгай орхих



## НУУЦ БАРИМТ БИЧИГ, БУСАД ТЭЭГЧИЙГ ХҮЛЭЭЛЦЭХ



### НУУЦ БАРИМТ БИЧИГ, БУСАД НУУЦ ТЭЭГЧИЙГ ХҮЛЭЭЛЦЭХ

- Өөр албан тушаалд шилжсэн,
- Ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд

Нууцтай танилцах  
эрх бүхий албан  
тушаалттан



Нууц хамгаалах  
ажилттан



Ажлын хэсэг

Ажлыг нь хүлээлцүүлнэ

- Албан томилолттой
- Эзлжийн амралттай
- Өвчтэй, чөлөөлтэй бол

Нууцтай  
танилцах эрх  
бүхий албан  
тушаалтны  
ажлыг

Байгууллагын  
удирдлагын  
шийдвэрээр

Адил түвшний  
нууцтай  
танилцах эрх  
бүхий албан  
тушаалтнаар түр  
гүйцэтгүүлнэ

/Маягт 21/-ын дагуу нотломж үйлдэнэ

**Нууц баримт бичиг, бусад тээгчийг нэг бүрчлэн тоолж ав, бүртгэ!!!**

**Хүлээлцэх үед нууц задарсан, үрэгдсэн тохиолдолд тагнуулын  
байгууллагад мэдэгдэх**



# 8

## НУУЦ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ, ХАДГАЛАХ, ДАМЖУУЛАХ СИСТЕМ, СҮЛЖЭЭ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ



Байгууллагын удирдлага нууц мэдээлэл боловсруулах, хадгалах, дамжуулах мэдээллийн систем, сүлжээ, техник хэрэгслийг аливаа аюул занал, хууль бус үйлдлээс хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг авсан байна.

Мэдээллийн систем сүлжээ, техник, хэрэгсэл

- Хууль тогтоомж
- Журам
- Стандарт

Тагнуулын байгууллагаас баталгаажуулсан

Байгууллага нь өөрийн онцлогт тохирсон мэдээллийн систем, сүлжээ, техник хэрэгсэл болон цахим мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулсан баримт бичигтэй байж болно.

Нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан

Нууц үг

Нууц хамгаалах ажилтанд хадгалуулна


**Нууц үг бусдад задарсан тохиолдолд яаралтай өөрчлөх, нууц хамгаалах ажилтанд мэдэгдэх**





## НУУЦ ХАМГААЛАХ АЖИЛТАН НУУЦ ҮГ ӨӨРЧЛӨХ НӨХЦӨЛ, ХУГАЦААГ ТОГТООНО

- ▶ Нууцад хамаарах цахим мэдээлэл болон мэдээллийн сан устгах, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөөц хуулбарыг хийх, цахим гарын үсгээр баталгаажуулах ажлыг тухайн байгууллага зохион байгуулна.
- ▶ Байгууллага нь төрийн нууц мэдээллийн систем, сүлжээ, компьютерт нэвтэрсэн хэрэглэгчийн нэр, хийсэн үйлдэл, хугацааг автоматаар бүртгэх программ хангамжтай байна. Бүртгэлийн мэдээллийг 6 сараас доошгүй хугацаанд хадгална.
- ▶ Нууцад хамаарах мэдээлэл агуулсан компьютерийн программ хангамжийн лиценз, шинэчлэлт, хяналтыг хийхдээ тагнуулын байгууллагын баталгаажуулсан нууцлал, хамгаалалттай төрийн тусгай хэрэглээний мэдээлэл холбооны сүлжээнээс бусад гадаад сүлжээнд холбоог хориглоно.
- ▶ Нууц мэдээллийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх аливаа сэжигтэй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд нууц хамгаалах ажилтан нотлох баримтыг үйлдэн бэхжүүлж, тагнуулын байгууллагад нэн яаралтай мэдэгдэнэ.
- ▶ Нууц мэдээлэл агуулж байгаа компьютер, техник хэрэгслийн засвар үйлчилгээ, эд анги нэмж суулгах, өөрчлөх, программ хангамжид үйлчилгээ хийх тохиолдолд тагнуулын байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр тухайн байгууллагын мэдээлэл технологийн ажилтан хийж гүйцэтгэнэ.





# 9

## НУУЦЫН БИЕТ ХАМГААЛАЛТ



### Нууцын биет хамгаалалтын арга хэмжээ

Хаалганы цоож	Цонхны төр	Харуул хамгаалалт (ажиглалт, хяналт)	Хаалганы хяналт (автоматжуулсан систем, дохиолопол)
---------------	------------	--------------------------------------	---

Нууц мэдээллийн хэмжээ, нууцын зэрэглэлээс хамааран байгууллагад хамгаалалтын бүс тогтоож, зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



- Гадны хүнийг зөвшөөрөлгүй нэвтрүүлэх
- Зөвшөөрөлгүй албан тушаалтан нэвтрүүлэх
- Цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тусгай өрөө, тасалгаанд суудаг албан тушаалтны хяналтгүй хийх

Нууц баримт бичиг, нууц тээгч


Зориулалтын сейф,  
агуулах хайрцаг

### НУУЦ ХАМГААЛАХ АЖИЛТНЫ ӨРӨӨНИЙ ШААРДЛАГА

- Хаалганы бат бөх цоож, нэвтрэх автоматжуулсан системтэй байх;
- Дохиоллын хамгаалалттай байх;
- Цонх нь хамгаалалтын тортой байх;
- Орох хаалганы дэргэд дүрст хяналттын системтэй байх;
- Нууц мэдээлэл бүхий серверийн өрөөнд хариуцсан ажилтнаас бусад хүн нэвтрэхэд зохих бүртгэл, хяналттай байна.



### НУУЦЫН ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ:





**Тагнуулын байгууллагын хяналт шалгалт:**

Төлөвлөгөөт

Төлөвлөгөөт бус

Гүйцэтгэлийн



**Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3 жил тутамд хийнэ.**



**Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх үндэслэл:**

Хууль тогтоомж зөрчсөн,  
нууц задруулсан,  
үргэгдуулсэн байж  
болзошгүй

Ерөнхийлөгч, УИХ,  
Засгийн газрын  
шийдвэрээр

Шүүх, прокурор, хууль  
сахиулах байгууллагын  
шийдвэрээр



**Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах албан шаардлагын хэрэгжилтийг  
хангах зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийнэ.**





# 10

## ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ



### ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГА

- ▶ Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- ▶ Төрийн болон албаны нууцыг ашиглаж, хамгаалж байгаа байдалд хяналт тавих, шалгах
- ▶ Төрийн болон албаны нууцыг хамгаалах техник, криптографийн хэрэгсэлд түршилт, шинжилгээ хийх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах
- ▶ Мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх
- ▶ Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг боловсронгуй болгох саналаа Засгийн газарт оруулах
- ▶ Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцыг зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлаар саналаа Засгийн газарт оруулах
- ▶ Төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, ашиглах
- ▶ Төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэнд аюулгүй байдлын шалгалт явуулах, төрийн болон албаны нууцыг ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх хуулийн этгээдийг судалж, шалгах
- ▶ Төрийн болон албаны нууцыг дамжуулах, илгээх мэдээлэл, шуудан харилцаа холбооны сүлжээ, шифр харилцааг улсын хэмжээнд болон хилийн чанадад зохион байгуулж, хяналт тавих
- ▶ Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах;
- ▶ Төрийн болон албаны нууцыг харилцан солилцох, хамгаалах асуудлаар байгуулах олон улсын гэрээ, хэлэлцээрийн төсөлд, санал, дүгнэлт өгөх.



## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ТАЙЛАН ИРҮҮЛЭХ:

Төрийн байгууллага нь төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад ирүүлнэ.

### ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН “ТУСГАЙ ДУГААР”:

Та төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаар болон нууцад хамаарах баримт бичиг, биет зүйлийг олсон, мөн алдагдаж, үрэгдсэн байж болзошгүй талаар ТЕГ-т биечлэн мэдэгдэх, эсхүл **9226-3716** дугаарын утас руу залган хандаж болно.



**9226-3716**

“Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-д заасны дагуу нууцыг хамгаалах чиглэлээр туслалцаа, дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдэд хөдөлмөрийн хөлслний доод хэмжээг 1-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн болон бусад хэлбэрийн урамшуулалт олгоно.





# 11

## ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА



Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, зөрчлийн болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

### ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИАС:

39.2. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагаас дараах хариуцлага хүлээлгүүлэхээр харьялах дээд шатны байгууллага, албан тушаалтанд санал тавьж шийдвэрлүүлнэ:

39.2.1. Энэ хуулийн 6.2, 6.3, 15.1 дэх хэсэг, 27, 28 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй, албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

39.2.2. Энэ хуулийн 6.2, 6.3, 15.1 дэх хэсэг, 27, 28 дугаар зүйлд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, мөн 38.4-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцуулах, төрийн албанаас халах.

39.3. Харьялах дээд шатны байгууллага, албан тушаалтан нь холбогдох албан тушаалтандaa энэ хуулийн 39.2-т заасан хариуцлага хүлээлгэж, энэ талаар 14 хоногийн дотор тагнуулийн байгууллагад хариу мэдэгдэнэ.

39.4. Энэ хуулийн 39.2-т заасныг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналыг тагнуулын байгууллагаас түүнийг томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

39.5. Тагнуулын байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шаардлага, шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, иргэн түүний дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэх үүрэгтэй.



## ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

### 19.11 дүгээр зүйл. Төрийн нууцыг хууль бусаар олж авах

1. Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлсийг хулгайлсан, цуглувансан, хадгалсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### 19.12 дугаар зүйл. Төрийн нууцыг задруулах

1. Төрийн нууцыг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн маш нууц, онц чухал нууцыг задруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### 19.13 дугаар зүйл. Төрийн нууцыг үрэгдүүлэх

1. Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас үрэгдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэлжээс арван дөрвөн мянган нэлжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.


2. Энэ гэмт хэргийн улмаас төрийн онц чухал, маш нууцыг үрэгдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэлжээс хорин долоон мянган нэлжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС:

15.14 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчих

1. Хуульд заасан:
  - 1.1. Төрийн болон албаны нууцад хамааруулах;
  - 1.2. Төрийн болон албаны нууцтай танилцах;
  - 1.3. Төрийн болон албаны нууцыг нууцлах, эсхүл ил болгох;
  - 1.4. Төрийн болон албаны нууцыг шилжүүлэх, эсхүл хамгаалах дэглэмийг хангах талаарх тогтоосон журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Төрийн болон албаны нууцад үл хамаарах мэдээлэл нууцалсан, эсхүл хувийн зорилгоор ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ТЭМДЭГЛЭЛ:

## ТЭМДЭГЛЭЛ:



